



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 23 өдөр

Дугаар A/643

Алтай хот

Улсын тэмдэгтийн хураамж
төлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлж, шүүхэд нэхэмжлэл гаргасан хуулийн этгээдийн нэхэмжлэл хангагдсан тул тус аймаг дахь сумд дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 133/ШШ2020/00409 дугаар шийдвэрээр "Хасагтын гоёл" ХХК-д төлөх 372023 (гурван зуун далан хоёр мянга хорин гурван) төгрөг, мөн шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 133/ШШ2020/00381 дугаар шийдвэрээр Мандал-Голомт ХХК-д төлөх 194922 (нэг зуун ерөн дөрвөн мянга есөн зуун хорин хоёр) төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг төлсүгэй.

2. Улсын тэмдэгтийн хураамжинд төлөх 566945 (таван зуун жаран зургаан мянга есөн зуун дөчин таван) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дансанд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Н.Наранцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ